

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 58 дугаар тэмдэглэлд:

“Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Орхон аймгийн Эрдэнэт хотоос Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Овоотын нүүрсний орд газар хүртэл 581 километр төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд ажлын журмаар тогтоол гаргахаар тогтов.

2. Эгийн голын усан цахилгаан станцын урьдчилсан шатны дэд бүтцийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Эрдэнэтийн Говил тосгоноос төслийн талбай хүртэлх 73.9 км авто зам болон 220 кВ-ын 2 хэлхээт 72.3 км цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж, барилга угсралтын ажил эхлэхэд бэлэн болсон тул Эрдэнэт хотоос Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Овоотын нүүрсний орд газар хүртэлх 581 километр төмөр замын суурь бүтэц барих ажлын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг уг төсөлтэй уялдуулан боловсруулахыг Зам, тээврийн сайд М.Зоригт, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР